



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/459

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 13 дугаар хорооны
“Эрүүл өсөх” өрхийн эрүүл мэндийн төвийн
Эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2,200,000 (хоёр сая хоёр зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 13 дугаар хорооны “Эрүүл өсөх” өрхийн эрүүл мэндийн төв (Н.Гүрбазар)-д зөвшөөрсүгэй.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001247

